МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

Нэгдсэн үндэстний гудамж 20, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Улаанбаатар 14200-0063
Утас: 70071113, 70071117
Цахим шуудан: secretariat@ncge.gov.mn
Цахим хуудас: www.gender.gov.mn

2024.05.28 № 127

танай _____-ны № _____-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА

Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр захирамжаар батлагдсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)"-г хавсралтаар хүргүүлж байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг салбар, орон нутаг, байгууллагынхаа бодлого, үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлж хамтран ажиллахыг Танаас хүсье.

Засгийн газрын тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, төлөвлөгөөг хавсаргав.

Хүндэтгэсэн,

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ЭНХБАЯР

УЛААНБААТАР ХОТ
2024041461 9917381 СТ323

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:

"19.3."Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)"-ний талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1."Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)"-г Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар батлахаар тогтов;

2.Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр Дугаар 71 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

1.“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)”-г хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санал санаачилгыг дэмжин ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, зорилтот түвшний үзүүлэлтэд 2026 онд зохих журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, дүнг танилцуулахыг Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба (Т.Энхбаяр)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ерөнхий сайдын 2024 оны 05 дугаар
сарын 14-ний өдрийн 71 дүгээр
захирамжийн хавсралт

ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮҮГ БАГАСГАХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2024-2027)

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	2024	2025	2026	2027	Хэрэгжилтийг хариуцсан байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
ЗОРИЛТ 1. ХӨВГҮҮД, ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ, АМЬДРАЛЫН ЗӨВ ДАДАЛ ХЭВШЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ЧАНАРТАЙ, УРТ НАСЛАЛТЫГ ДЭМЖИХ										
1.	**Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг сайжруулах замаар чанартай, урт наслалтыг дэмжих**	**Эрэгтэйчүүдийн нас баралтын зонхилох шалтгаан, дүнд эзлэх хувь**	**32**	**30**	**31.5**	**31**	**30.5**	**30**	**Холбогдох төрийн байгууллагууд**	**Холбогдох төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд**
1.1	Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт (БЕХ-ийн 14.4.2, 14.4.3 заасан) "Эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшил" сэдвээр бие даасан агуулга оруулж, нэвтрүүлэх	Бие даасан агуулгаар суралцагчдын хувь	0	100	20	40	60	100	Боловсрол, шинжлэх ухааны яам	Бүх түвшний боловсролын байгууллага
1.2	0-17 насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч нарт чиглэсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эрүүл өсөж, бойжих эрхийг хангах, энэ талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээ зохион байгуулах	Зорилтот арга хэмжээний тоо, хамрагдсан эцэг, эхийн хувь	0	100	10	40	80	100	Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яам	Төрийн бус байгууллагууд

1.3	0-12 насны хүүхэдтэй эцэг, эх, өрх толгойлсон эцэг/эхийн гэр бүлдээ зарцуулах цагийг уртасгах боломжийг байгууллага, аж ахуйн нэгжийн түвшинд бүрдүүлэх, сайн туршлагыг сурталчлах	Ажлын цагт уян хатан бодлого хэрэгжүүлсэн байгууллага, нийт аж ахуйн нэгж байгууллагын эзлэх хувь	0	25	10	15	20	25	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жендэрийн үндэсний хороо	Төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд
1.4	"Стрессгүй ажлын орчин", "Стрессгүй өрх, гэр бүл" зэрэг аян өрнүүлэх замаар сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх, стрессийг даван туулах, амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, зөвлөгөө өгөх	Аймаг, дүүрэг бүрд зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, жил бүрээр	0	30	10	20	30	30	Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, төрийн бус байгууллагууд
1.5	Эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээнээс татгалзахыг уриалсан тайз, дэлгэцийн уран бүтээл захиалж хийлгэх, дэмжлэг үзүүлэх	Уран бүтээлийн тоо	0	4	1	2	3	4	Соёлын яам	Мэргэжлийн урлагийн байгууллагууд
1.6	Эрэгтэйчүүдийн сонирхлоор нэгдсэн клуб, спортын төрлөөр дамжуулан эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах, зөвлөгөө өгөх, зөв үлгэр дуурайлал үзүүлж буй бүлэг, клубийг дэмжих, сурталчлах	Аймаг, дүүрэг бүрд зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, жил бүрээр	0	30	10	20	30	30	Биеийн тамир, спортын улсын хороо	Төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд
1.7	"Эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшил", "Архи, тамхи, мансууруулах бодисын	Жил бүр гаргасан нийтлэл, нэвтрүүлгийн тоо	0	16	4	8	12	16	Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Монголын	Төрийн бус, аж ахуйн нэгж,

	хэрэглээг бууруулах", "Авто ослоос сэргийлэх, бууруулах" чиглэлээр шилдэг нийтлэл, нэвтрүүлгийг жил бүр шалгаруулж урамшуулах								хэвлэлийн хүрээлэн, Хэвлэл мэдээллийн зөвлөл болон хэвлэл мэдээллийн байгууллагууд	олон улсын байгууллагууд
1.8	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг жил бүр зохион байгуулахаар тусгаж, эрэгтэй албан хаагчдын хамрагдалт, оролцсон байдалд тусгайлан анхаарах, сайн туршлагыг түгээх	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахыг төлөвлөсөн, хэрэгжүүлсэн байгууллагын хувь	0	30	15	20	25	30	Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жендэрийн үндэсний хороо	Төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд
1.9	Үндэсний хэмжээний мэдээллийн системийг (E-MONGOLIA) ашиглаж эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдах талаар болон эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх мэдээ, мэдээллийг тогтмол түгээх	Мэдээллийн системээр тогтмол түгээсэн мэдээ, мэдээллийн тоо	0	16	4	8	12	16	Цахим хөгжил, харилцаа, холбооны яам	Эрүүл мэндийн яам
1.10	Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах	Зохион байгуулсан эсэх	0	1	0	1	1	1	Биеийн тамир, спортын улсын хороо, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд

1.11	ЕБС-ийн нийгмийн ажилтан (сэтгэл зүйч)-д хүйсийн онцлог хэрэгцээнд нийцсэн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадвар эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр бий болгох, хамруулах	Сургалтад хамрагдсан нийгмийн ажилтны хувь	0	50	20	30	40	50	Боловсрол, шинжлэх ухааны яам	Эрүүл мэндийн яам
1.12	Зүрх судас, артерийн даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 20 наснаас дээш насны эрэгтэйчүүдийг артерийн даралтаа хэмжих, хянахад хэвшүүлэх, "80/120" богино хугацааны нөлөөллийн аяныг тогтмол зохион байгуулах	Аймаг, дүүрэгт зохион байгуулагдах урьдчилан сэргийлэх мэдлэг олгох үйл ажиллагааны тоо	0	60	30	30	60	60	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд
1.13	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт гэр бүлээрээ, хамтдаа хамрагдах замаар эрүүл мэндийг дэмжигч гэр бүл санаачилгыг төлөвлөж, хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт гэр бүлээрээ орсон өрхийн хувь	0	20	0	10	15	20	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Эрүүл мэндийн яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, төрийн бус байгууллагууд
1.14	"Наслахын жаргалыг хамтдаа" зэрэг богино хугацааны нөлөөллийн арга хэмжээг засаг захиргааны анхан шатны нэгжийн түвшинд тогтмол зохион байгуулж, үр дүнг олон нийтэд таниулан сурталчлах	Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан засаг захиргааны анхан шатны нэгжийн хувь	0	50	20	30	40	50	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Бүх шатны Засаг даргын тамгын газар, төрийн бус, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагууд
ЗОРИЛТ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ХАМРАГДАЛТ, ОРОЛЦООГ ТОГТМОЛЖУУЛАХ										

2.	**Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эрэгтэйчүүдийн хамрагдалт, оролцоог тогтмолжуулах**	**Үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн хувь**	**30**	**70**	**35**	**45**	**55**	**70**	**Холбогдох төрийн байгууллагууд**	**Холбогдох төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд**
2.1	Эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрсдэлээс хамгаалах, хариу арга хэмжээний талаарх мэдээллийг жилд 4-өөс доошгүй удаа түгээх, эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшил бий болгох чиглэлээр тогтмол аян өрнүүлэх	Аймаг/нийслэлийн түвшинд эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хувь	30	70	35	45	55	70	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Эрүүл мэндийн яам
2.2	0-17 хүртэлх насны хөвгүүдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хяналтын дор эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-ээс доошгүй удаа хамруулах	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хөвгүүдийн хувь	30	100	30	60	90	100	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Эрүүл мэндийн яам
2.3	Их, дээд сургууль, МСҮТ, коллежид суралцаж буй эрэгтэй оюутныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хичээлийн жилд 1-ээс доошгүй удаа хамруулах	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эрэгтэй оюутан, сурагчдын хувь	20	100	40	60	80	100	Боловсрол, шинжлэх ухааны яам	Эрүүл мэндийн яам
2.4	Малчны хотонд хүрч, малчин эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах боломжийг бүрдүүлэх (жилд 1-ээс доошгүй удаа)	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан малчин эрэгтэйчүүдийн хувь	30	70	30	50	60	70	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Эрүүл мэндийн яам

2.5	Нийгмийн зорилтот бүлгийн болон халамж үйлчилгээ нэн шаардлагатай (ахмад настан, тусгай хэрэгцээт, орон гэргүй, архины хамааралтай) эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-ээс доошгүй удаа хамруулах	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нийгмийн зорилтот бүлгийн эрэгтэйчүүдийн хувь	0	50	15	35	45	50	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Эрүүл мэндийн яам, төрийн бус байгууллагууд
2.6	Төрийн цэргийн болон тусгай чиг үүрэг бүхий байгууллага, уул уурхай, барилга, зам тээврийн зэрэг үйл ажиллагааны онцлогоос хамааран эрэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагын эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	Салбар бүрээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хувь	30	100	30	60	90	100	Холбогдох яам, агентлагууд	Эрүүл мэндийн яам
2.7	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет /андрологи/ байгуулах, хүний нөөц, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслээр хангах	Үйл ажиллагаа нь бүрэн тогтворжсон кабинетын хувь, /андрологи/	77	100	77	87	97	100	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Эрүүл мэндийн яам
2.8	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас шийдвэрлэх бололцоог бүрдүүлж хэвшүүлэх	Эрүүл мэндийн даатгалаар урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн хувь	0	50	10	20	40	50	Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Сангийн яам

2.9	Халдварт бус өвчлөл, нас баралтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, сайн дурын ажилтныг чадавхжуулах замаар эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Чадавхжуулах үйл ажиллагаанд хамрагдсан нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сайн дурын ажилтны хувь	0	30	5	10	20	30	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Эрүүл мэндийн яам, олон улсын байгууллага
2.10	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах үйл ажиллагааг дэмжиж, олон нийтэд таниулан сурталчлах, дэвшилтэд технологи (App болон чатбот) ашиглан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Тогтмол зохион байгуулж буй арга хэмжээний тоо	0	16	4	8	12	16	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Төрийн, төрийн бус, аж ахуй нэгж, олон улсын байгууллагууд
ЗОРИЛТ 3. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ОСОЛ ГЭМТЭЛ, ЗУУРДЫН НАС БАРАЛТЫГ БУУРУУЛАХ										
3.	**Зам тээврийн ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах замаар эрэгтэйчүүдийн осол гэмтэл, зуурдын нас баралтыг бууруулах**	**Эрэгтэйчүүдийн нас баралтын зонхилох шалтгаан, осол гэмтэл, зуурдын нас баралтын нийт нас баралтад эзлэх хувь**	**25**	**21**	**24**	**23**	**22**	**21**	**Холбогдох төрийн байгууллагууд**	**Холбогдох төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд**
3.1	Олон улсын болон улсын чанартай авто замын стандартыг мөрдүүлэх, замын засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх, олон нийтийг мэдээллээр хангах	Одоогийн түвшнийг тодорхойлж стандартыг мөрдүүлсэн эсэх	0	1	0	0	1	1	Зам, тээврийн хөгжлийн яам	Цагдаагийн ерөнхий газар

3.2	Авто замын дагуу камерын хяналтын системээр тээврийн хэрэгслийн хурд, бусад зөрчлийг хянах мэдээллийн нэгдсэн системийн программ, техник хангамжийн хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлэх	Нэгдсэн систем хөгжүүлж эхлүүлсэн эсэх	0	1	0	0	1	1	Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Бүх шатны Засаг даргын Тамгын газар
3.3	Автомашин, мотоцикл, орчин цагийн моторт тээврийн хэрэгсэл (цахилгаан унадаг дугуй, скүүтер, мопед)-ийг жолоодох мэргэшил эзэмшүүлэх, эрх олгох сургалт, шалгалт, хяналтын одоогийн зохицуулалтад эрх зүйн болон үйл ажиллагааны шинэчлэлт хийх	Эрх зүйн шинэчлэл хийсэн эсэх	0	1	0	1	1	1	Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Зам, тээврийн хөгжлийн яам, Цагдаагийн ерөнхий газар
3.4	Малчин эрэгтэйчүүдийн ашиглаж буй стандартын бус мотоциклын хэрэглээг багасгах, түүнээс шалтгаалсан ослыг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Мотоциклын ослоос шалтгаалсан нас баралтын хувь	10	6	9	8	7	6	Цагдаагийн ерөнхий газар	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, Соёлын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гэмтэл, согог судлалын үндэсний төв
3.5	Эрэгтэйчүүдийн нас, эрхэлж буй ажил, салбарын онцлог, амьдарч буй байршил зэргийг харгалзсан зам тээврийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг цахим орчинд жилд 4-өөс доошгүй	Бэлтгэн түгээж, тогтмолжсон контентын тоо	0	16	4	8	12	16	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл,	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, төрийн бус байгууллагууд

	удаа түгээж, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах								Цагдаагийн ерөнхий газар	
3.6	Амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 24 цагийн утсаар зөвлөгөө, мэдээлэл өгөх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	Тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн эсэх	0	1	0	0	1	1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар	Төрийн бус, олон улсын байгууллагууд
3.7	Эрэгтэйчүүд олноор ажиллаж буй төрийн тусгай чиг үүргийн болон дэд бүтцийн салбарын байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэх, энэ талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах замаар үйлдвэрлэлийн ослыг бууруулах	Тухайн салбар бүрээр, үйлдвэрлэлийн ослоос шалтгаалсан нас баралтын хувь	100	50	100	85	65	50	Холбогдох яам, агентлагууд	Төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд
ЗОРИЛТ 4. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХҮЙСЭЭР АНГИЛСАН МЭДЭЭЛЛИЙГ ӨРГӨТГӨН САЙЖРУУЛАХ, ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ТУСГАХ ЗАМААР ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ										
4.	**Үндэсний хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийг өргөтгөн сайжруулах, жендэрийн дүн шинжилгээ хийх, хөгжлийн бодлогод тусгах замаар олон талт хамтын ажиллагааг дэмжих**	Иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын дүнд эзлэх хувь	**30**	**100**	**30**	**50**	**70**	**100**	**Холбогдох төрийн байгууллагууд**	**Холбогдох төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагууд**
4.1	Үндэсний хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийн санг өргөжүүлэх, тогтвортой, хүртээмжтэй байдлаар нийтийн хүртээл болгох	Хүйсээр ангилсан өгөгдөл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжилтын хувь	25	80	45	65	75	80	Үндэсний статистикийн хороо, Жендэрийн үндэсний хороо	Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аж

										ахуйн нэгж байгууллага
4.2	Суурь судалгаа болон нас баралтын шалтгааны судалгааг явуулж, гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийх, нийтийн хүртээл болгох	Судалгааны тоо	1	4	1	2	3	4	Жендэрийн үндэсний хороо	Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам, олон улсын байгууллага
4.3	Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хөгжүүлэх бодлогыг үндэсний түвшинд сурталчлах, хэрэгжилтийг хангасан хуулийн этгээдийг урамшуулах, сайн туршлагыг түгээх	Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хэрэгжүүлсэн хуулийн этгээд, байгууллагын дүнд эзлэх хувь	0	30	0	10	20	30	Жендэрийн үндэсний хороо	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэл
4.4	Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах	Аймаг, дүүрэгт иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын дүнд эзлэх хувь	30	100	30	50	70	100	Бүх яам, Жендэрийн үндэсний хороо	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, олон улсын байгууллага
4.5	Хугацаат цэргийн албанд татагдаж буй эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэлд тулгуурлан цэргийн насны залуучуудын эрүүл мэндэд тулгамдаж	Судалгаа зохион байгуулсан эсэх	0	1	0	1	1	1	Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам	Төрийн бус, олон улсын байгууллага

	байгаа асуудлаар судалгаа зохион байгуулах									

---oOo---